

АУДИТАД АЖИЛЛАХ ШИНЖЭЭЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ,
ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, ДҮГНЭХ, ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН
ЧАНАРЫГ ХЯНАХ, ЖУРМЫН ШИНЭЧЛЭН НАЙРУУЛГЫН
ТАНИЛЦУУЛГА

2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2020 оны 05 дугаар сарын 01-нд батлагдсантай холбогдуулан тус хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-т “Төрийн аудитын байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шинжээчийг зохих журмын дагуу томилон ажиллуулж болно”, 17.6-д “Энэ хуулийн 17.1-д заасан шинжээчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор батална” гэж заасныг үндэслэн “Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ыг Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/82 дугаар тушаалаар батлан Захиргааны хэм хэмжээний актад бүртгүүлэн хэрэгжүүлэн ажиллаж байна.

Захиргаа, хууль эрх зүйн газар нь дээрх журмуудын хэрэгжилтийг хангаж, 2021-2023 онд гүйцэтгэл, нийцлийн аудитад жилд дунджаар 30 орчим ажилд шинжээч сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулж, нийт 81 шинжээчтэй 3,113.6 сая төгрөгийн гэрээ байгуулан, гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг дүгнэсэн.

Мөн 2023 онд санхүүгийн тайланд аудит гүйцэтгэх аудитын хуулийн этгээдийн сонгон шалгаруулах үйл ажиллагааг 143 багцаар зохион байгуулж, гэрээ байгуулан ажилласан.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль 2023 оны 06 дугаар сард шинэчлэн батлагдаж, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөгдөж байгаатай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/82 дугаар тушаалаар баталсан “Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах” журам болон Монгол Улсын Ерөнхий аудиторов аудиторов 2020 оны А/92 дугаар тушаалаар “Загвар маягт батлах тухай” тушаалыг шинэчлэн боловсруулах шаардлага үүссэн.

Төрийн аудитын тухай хуульд аудитад шинжээч оролцуулах худалдан авах ажиллагааг дээрх хуулиар зохицуулахгүй гэж заасан боловч шинжээч сонгон шалгаруулах үйл ажиллагааны үндсэн зарчим нь тус хууль, түүнийг дагалдан гарсан холбогдох журмуудтай уялдуулах шаардлагатай гэж үзсэн.

Мөн журмын хэрэгжилтийн явцад шинжээчийн ажлын төлөвлөлт, тайлагналт, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах ажлын хэсгийн үйл ажиллагааны чиг үүрэг, түүний хөшүүрэг, шинжээчийн ажлын гүйцэтгэлийг хүлээн авахтай холбогдсон нарийвчилсан зохицуулалт шаардлагатай болсон.

Түүнчлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/92 дугаар тушаалаар баталсан “Загвар маягт батлах тухай” тушаал нь дээрх А/82 дугаар тушаалыг хэрэгжүүлэх хүрээнд гарсан худалдан авах үйл ажиллагаанд ашиглах загвар маягтууд тул тус журмын шинэчилсэн найруулгад журмын хавсралт болгон оруулснаар, сонгон шалгаруулах үйл ажиллагааг нэг журмаар зохицуулахаар боловсруулагдлаа.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/82 дугаар тушаалаар баталсан “Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах” журам нь 7 зүйл, 42 хэсэг, 23 заалт, 2 хавсралтаас бүрдэж байсан бол “Аудитад ажиллах шинжээчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах, журам”-ын шинэчлэн найруулгын төсөл нь 8 зүйл, 65 хэсэг, 25 заалт, 4 хавсралтаас бүрдсэн.

Журмын шинэчилсэн найруулга болон тушаалын төсөлд санал авах явцад холбогдох бүтцийн нэгжүүдээс 97 заалтад тодорхой санал ирүүлсэн бөгөөд ирсэн саналыг журмын төсөлд тусгасан. /Саналын 70 хувийг хүлээн авч тусгав/

--oOo--

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛЫН ТӨСӨЛ

Аудитад ажиллах шинжээчийг сонгон шалгаруулах,
гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын
чанарыг хянах, журмыг шинэчлэн батлах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.3 дахь заалт, 29.3 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1, 64.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Аудитад ажиллах шинжээчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ыг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан журмыг Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх ажлыг Захиргаа, хууль эрх зүйн газар (С.Батбямба)-д, улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдэж хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Төрийн аудитын байгууллагын газрын дарга, захирал, тэргүүлэх аудитор нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (Ц.Баярмаа)-т даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/82 дугаар тушаалаар баталсан “Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”, мөн 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/92 дугаар тушаалаар баталсан “Загвар, маягт батлах тухай” тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ЗАГДЖАВ

АУДИТАД АЖИЛЛАХ ШИНЖЭЭЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, ДҮГНЭХ, ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ЧАНАРЫГ ХЯНАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Үндэсний аудитын газар болон аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар (цаашид “Төрийн аудитын байгууллага” гэх) нь аудитад ажиллах шинжээчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах, харилцаанд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.2. Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэлийн, нийцлийн, санхүүгийн тайлангийн аудитын үйл ажиллагаанд гэрээний үндсэн дээр оролцох шинжээч нь тухайн ажлыг гүйцэтгэх салбарын чиглэлээр мэргэшсэн, ажлын туршлагатай, хараат бусаар ажиллах шаардлагыг хангасан, эрх бүхий хувь хүн, баг, хуулийн этгээд байна.

1.3. Энэхүү журам нь Төрийн аудитын тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төсвийн тухай хууль, Аудитын тухай хууль түүнд нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актыг үндэслэнэ.

1.4. Төрийн аудитын байгууллага нь аудитад дараах тохиолдолд шинжээчийг гэрээгээр ажиллуулна. Үүнд:

1.4.1. аудитад бодлогын болон нарийн мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж боловсруулах;

1.4.2. аудитад тодорхой асуудлаар лабораторийн шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулах,

1.4.3. Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т заасны дагуу санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгүүлэх;

1.5. Төрийн аудитын байгууллага нь аудитад шинжээч ажиллуулах болон санхүүгийн тайлангийн аудитыг аудитын хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх тохиолдолд захиалагч байх бөгөөд захиалагчийг төлөөлөх этгээд нь Монгол Улсын Ерөнхий аудитор, эсхүл түүний эрх олгосон албан тушаалтан байна.

1.6. Төрийн аудитын байгууллага нь гүйцэтгэл, нийцлийн аудитад оролцох шинжээч болон Төсвийн тухай хуулийн 8.9.1 (төсвийн шууд захирагч), 8.9.8 (Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд)-д тусгагдсан этгээдийн санхүүгийн тайланд хийх аудитыг гүйцэтгэх этгээдийг энэ журмын дагуу сонгон шалгаруулна.

1.7. Санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх хуулийн этгээд нь Аудитын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т заасан шаардлагыг хангасан байна. Орон нутаг дахь Төрийн аудитын газар нь удаа дараа сонгон шалгаруулалт зохион байгуулахад шаардлага хангасан санал ирээгүй, аудитын хуулийн этгээдийн тоо хязгаарлагдмал нөхцөлд санхүүгийн тайлангийн аудитыг эрх бүхий хувь хүн, багаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

1.8. Санхүүгийн тайлангийн аудит гүйцэтгэсэн аудитын хуулийн этгээд, хувь хүн болон багийн ажлын гүйцэтгэлийг хянах, баталгаажуулахад Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журмыг мөрдөнө.

1.9. Сонгон шалгаруулалтад оролцогчийн мэдээлэл, шинжээчийн гүйцэтгэсэн ажлын үнэлгээгээр Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-т заасан мэдээллийн сан үүсгэх бөгөөд уг санг шинжээч сонгон шалгаруулах үйл ажиллагаанд ашиглаж болно.

ХОЁР. ШИНЖЭЭЧИЙН ЗАРДАЛ, ТҮҮНИЙ ТӨЛӨВЛӨЛТ, ТАЙЛАГНАЛТ

2.1 Төрийн аудитын байгууллагын аудит хийх чиг үүрэг бүхий бүтцийн нэгжүүдээс ирүүлсэн аудитын сэдвийн саналын талаарх судалгаанд үндэслэн аудитад шаардлагатай хөндлөнгийн шинжээчийн судалгаа, тооцоолол төсөв, хүний нөөц зэргийг судалж, санал боловсруулна.

2.2. Шинжээчийн нийт зардал нь дараах зардлуудаас бүрдсэн байна. Үүнд:

- 2.2.1. шинжээчийн ажлын хөлс;
- 2.2.2. ажил олгогчоос төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэл;
- 2.2.3. бусад зардал.

2.3. Шинжээчийн ажлын хөлсийг тооцоолохдоо ажлын цар хүрээ, нарийн төвөгтэй байдал, мэргэжлийн ур чадвар, үүсэж болох эрсдэл, хүлээх хариуцлага, шинжээчийн дүгнэлт боловсруулах хугацааг харгалзана.

2.4. Шинжээчийн ажиллах хугацааны нэг хоногийг ажлын 8 цагаар тооцно.

2.5. Шинжээчийн зардал нь Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.7-д заасан хэмжээнд багтсан байна.

2.6. Төрийн аудитын байгууллагын Захиргаа, хууль, эрх зүйн асуудал хариуцсан бүтцийн нэгж нь тухайн жилд гүйцэтгэх аудитын болон жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан энэ журмын 1.4.3-т зааснаас бусад шинжээчийг аудитад оролцуулах төлөвлөгөөний төслийг төсвийн тооцооллын хамт эцэслэн боловсруулж, тухайн төсвийн жилд гүйцэтгэх аудитад шинжээч ажиллуулах төлөвлөгөөг энэхүү журмын 1 дүгээр хавсралтын маягт 1-ийн дагуу Монгол Улсын Ерөнхий аудитор, эсхүл түүний эрх олгосон албан тушаалтнаар дараа оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор батлуулна.

2.7. Төрийн аудитын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасан төлөвлөгөөт бус аудитыг гүйцэтгэхэд шинжээч оролцуулах шаардлага гарсан тохиолдолд шинжээчийн зардлын төсөв тооцооллыг аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалт хариуцсан нэгж тухайн үед нь тооцож, шийдвэрлүүлэн ажиллана.

2.8. Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалт хариуцсан нэгж нь Санхүүгийн аудит хариуцсан чиг үүрэг бүхий бүтцийн нэгж болон аймаг, нийслэл дэх төрийн аудитын газраас ирүүлсэн саналыг үндэслэн аудитын хуулийн этгээдээр аудит гүйцэтгүүлэх байгууллагын жагсаалт гаргаж 08 дугаар сарын 10-ны өдрийн дотор Монгол Улсын Ерөнхий аудитор, түүний эрх олгосон албан тушаалтнаар батлуулна.

2.9. Шалгадагч этгээдийн өмчийн хэлбэр, аудитын цаглавар, аудит гүйцэтгэх цаг хугацаа, эрсдэлийн үнэлгээ, аудитын үйлчилгээний төлбөр, газар зүйн байршил зэргийг харгалзан аудитад багцыг үүсгэж болно.

2.10. Худалдан авах үйл ажиллагаа хариуцсан албан тушаалтан тухайн жилийн шинжээчийн төлөвлөгөөний хэрэгжилтийг энэ журмын 1 дүгээр хавсралтын маягт 2-ын дагуу боловсруулан захиалагчид улирал бүрийн 25-ны өдөр тайлагнана.

2.11. Тухайн төсвийн жилд гүйцэтгэх аудитад шинжээч ажиллуулах төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг зохион байгуулаагүй, төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй үндэслэлийг холбогдох маягтын тайлбар хэсэгт тусгана.

2.12. Батлагдсан төлөвлөгөөнд шаардлагатай тохиолдолд Монгол Улсын Ерөнхий аудитор, түүний эрх олгосон албан тушаалтны шийдвэрээр нэмэлт, өөрчлөлт оруулж батлуулна.

ГУРАВ. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ШИНЖЭЭЧИД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

3.1. Үндэсний аудитын газар болон аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар нь энэ журмын 2.7, 2.9-д заасан батлагдсан төлөвлөгөөний дагуу шинжээч сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулна.

3.2. Шинжээчийн ажлын даалгаврыг захиалагч нэгж болон аудитын баг энэ журмын 1 дүгээр хавсралтын маягт 3-ын дагуу боловсруулан Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч, аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын Тэргүүлэх аудитораар батлуулан, худалдан авах үйл ажиллагаа хариуцсан албан хаагчид хүргүүлнэ.

3.3 Үндэсний аудитын газарт ажлын даалгаврын төслийг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газраар хянуулсан байна.

3.4. Шинжээч сонгон шалгаруулах ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхий аудитор, эсхүл түүний эрх олгосон албан тушаалтан, аймаг нийслэл дэх Төрийн аудитын газрын тэргүүлэх аудиторын тушаалаар захиалагч нэгжээс 2-оос дээшгүй төлөөлөл оролцуулан сондгой тоо бүхий 5-7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулна.

3.5. Шинжээч сонгон шалгаруулах ажлын хэсэг нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс (цаашид ажлын хэсэг гэх) бүрдэх бөгөөд дараах шаардлага хангасан байна:

3.5.1. худалдан авах ажиллагаагаар мэргэшсэн байх;

3.5.2. тухайн салбарын иргэн, хуулийн этгээдтэй сүүлийн 3 жилийн хугацаанд хамаарал бүхий ажил эрхлээгүй байх.

3.6. Ажлын хэсэг нь сонгон шалгаруулах үйл ажиллагааг журмын хүрээнд зохион байгуулах бөгөөд дараах үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.6.1. Ажлын хэсгийн гишүүнээр томилогдсон даруйд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийн загварын дагуу тухайн үйл ажиллагаанд оролцоход ашиг сонирхлын зөрчилтэй эсэхээ мэдэгдэх;

3.6.2. Сонгон шалгаруулалтын явцад ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөл үүссэн, эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал илэрсэн бол холбогдох журмын дагуу мэдүүлэх бөгөөд, ажлын хэсгийн үүрэгт ажлаас чөлөөлөх эсэхийг шийдвэрлүүлэх;

3.6.3. Шинжээч сонгон шалгаруулах үйл ажиллагааны хуралд цаг тухайд нь оролцох үүрэг хүлээх ба гишүүн бүр саналын нэг эрх эдэлж, хуралд саналаа илээр өгч оролцох;

3.6.4. Ажлын хэсгийн дарга нь сонгон шалгаруулах үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, ажлын хэсгийг зөвхөн захиалагчийн өмнө төлөөлөх;

3.6.5. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нь хурлын товыг зарлах, хурлыг зохион байгуулах, тэмдэглэл хөтлөх, баталгаажуулах, сонгон шалгаруулах үйл ажиллагааны зар мэдээлэл болон холбогдох баримт бичгийг олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэх, баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж хуульд заасан хугацаанд байгууллагын архивд шилжүүлэх.

3.6.6. Ажлын хэсэг нь шинжээч сонгон шалгаруулах үйл ажиллагаанд холбогдох асуудлаар сонирхогч этгээд, оролцогч, тэдгээрийн төлөөлөлтэй албан бичиг, захидлаар харилцана.

3.7. Захиалагч нь албан тушаалын тодорхойлолтоор худалдан авах үйл ажиллагаа зохион байгуулах чиг үүрэгтэй ажилтнаас бусад гишүүнд хуралд оролцсон цаг тутамд албан тушаалын үндсэн цалингийн нэг цагийн жишгээр дүйцүүлэн урамшууллыг тооцоолон төсөвт багтаан олгож болно.

3.8. Ажлын хэсэг нь журмын хоёрдугаар хавсралтын дагуу шинжээч сонгох зарлал, саналын урилгын баримт бичгийн төслийг боловсруулж, захиалагчаар батлуулан, зар, мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй, ил тод мэдээлнэ.

3.9. Шинжээчийн сонгон шалгаруулалтыг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлан зохион байгуулах бөгөөд энэхүү журмын хүрээнд мэдээллийн технологи ашиглан зохион байгуулж болно.

3.10. Ажлын хэсгийн хуралд тухайлсан асуудал бүрээр санал хурааж, хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

3.11. Ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтын баримт бичигт тусгагдсан шалгуур үзүүлэлт болон үнэлгээний маягт загварын дагуу үнэлгээ, дүгнэлт хийж, хурлын тэмдэглэл, шийдвэрийг захиалагчид хүргүүлэн ажиллана.

3.12. Аудитын төрөл, хэлбэр, гэрээт ажлын онцлогоос шалтгаалан шинжээчид тавигдах тусгай шаардлагыг ажлын даалгаварт нарийвчлан тусгах бөгөөд дараах нийтлэг шаардлага тавигдана. Үүнд:

3.12.1. санхүүгийн тайлангийн аудит гүйцэтгэх аудитын хуулийн этгээд нь аудитын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй байна. Хувь хүн, багийн гишүүний хувьд аудиторын батламжтай байх;

3.12.2. шинжээчээр ажиллах этгээд нь ажлын даалгаварт заасан мэргэжлийн чиглэлээр нарийн мэргэшсэн, эрдмийн зэрэг цолтой, тухайн ажлыг үзүүлэх эрх бүхий байх;

3.12.3. тухайн салбарт ажилласан туршлагатай байх.

3.13. Шинжээчийг ажиллуулах хугацаа нь ажлын даалгаварт заасан ажлыг гүйцэтгүүлэхэд тохирсон байх бөгөөд аудитыг гүйцэтгэх хугацаанаас богино байна.

3.14. Сонгон шалгаруулалтад оролцогч этгээдийн ирүүлсэн санал нь санал хүлээн авахаар товлосон өдрөөс ажлын 30 хоногийн хугацаанд хүчинтэй байх ба шалгарсан этгээдтэй уг хугацаанд багтаж гэрээ байгуулна.

ДӨРӨВ. ШИНЖЭЭЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1. Захиалагч нэгжээс ирүүлсэн баталсан ажлын даалгаврыг үндэслэн 20 сая төгрөг хүртэлх төсөвт өртөг бүхий ажлын шинжээч сонгон шалгаруулалтыг Үндэсний аудитын газар болон аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын Захиргаа, хууль эрх зүйн асуудал хариуцсан бүтцийн нэгж, худалдан авах үйл ажиллагаа хариуцсан албан хаагч, 20 сая төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий ажлын шинжээчийг энэ журмын 3.4 дэх хэсэгт заасан ажлын хэсэг тус тус зохион байгуулна.

4.2 Санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх аудитын хуулийн этгээдийг сонгон шалгаруулахдаа 20 сая төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий ажилтай дүйцүүлэн, журмын дагуу зохион байгуулна.

4.3. Захиргаа, хууль эрх зүйн асуудал хариуцсан бүтцийн нэгж, худалдан авах үйл ажиллагаа хариуцсан албан хаагч болон ажлын хэсэг нь дараах байдлаар шинжээчийг сонгон шалгаруулна:

4.3.1. Худалдан авах үйл ажиллагаа хариуцсан албан хаагч эсвэл ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нь шинжээч сонгон шалгаруулах тухай зарлал бүхий саналын урилгын баримт бичиг (шинжээчид тавигдах шаардлага, ирүүлэх материал, хугацаа, төсөв бүхий)-ийг өдөр тутмын хэвлэл, байгууллагын цахим хуудас, олон нийтийн цахим сүлжээгээр дамжуулан нийтэд мэдээлнэ.

4.3.2. Сонгон шалгаруулалтад оролцогч нь захиалагчийн хүргүүлсэн зарлал болон баримт бичигт дурдсан шаардлагын дагуу саналаа боловсруулж ирүүлнэ.

4.3.3. Сонгон шалгаруулалтад оролцогчийн хүсэлт хүлээн авах хугацаа нь 20 сая төгрөг хүртэлх төсөвт өртөг бүхий ажилд зар нийтэлснээс хойш ажлын 3 хоног, 20 сая төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий ажилд зар нийтэлснээс хойш ажлын 5 хоног байна.

4.3.4. Санал хүлээн авах эцсийн хугацаа дуусмагц санал ирүүлсэн этгээдийн бүртгэлийг энэ журмын гуравдугаар хавсралтын маягт 1-ийн дагуу хөтөлж, баримтжуулна.

4.3.5. Санал ирүүлсэн этгээдийн материалыг хүлээн авсан даруй хянан үзэх үйл ажиллагааг эхлүүлэх ба 20 сая төгрөг хүртэлх төсөвт өртөг бүхий ажилд ирүүлсэн саналыг энэ журмын гуравдугаар хавсралтын маягт 2-ын дагуу, 20 сая төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий ажилд ирүүлсэн саналыг тус хавсралтын маягт 3, 4, 5, 6-ын дагуу тус тус хянан үзнэ.

4.3.6 “Хамгийн сайн” гэж дүгнэгдсэн саналын мэдээллийг гуравдугаар хавсралтын маягт 7-ын дагуу, бусад оролцогчдод шалгараагүй тухай дүгнэлтийг ажлын 7 хоногийн дотор захиалагчид хүргүүлнэ.

4.4. Захиалагч нь сонгон шалгаруулах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах ба сонгон шалгаруулалтын үнэлгээ, дүгнэлтийг шаардлагад нийцсэн гэж үзвэл сонгон шалгаруулалтаар "хамгийн сайн" үнэлэгдсэн этгээдэд шалгарсан, бусад оролцогчид шалгараагүй үндэслэл бүхий мэдээллийг албан бичгээр адил хугацаанд мэдэгдэнэ.

4.5. Сонгон шалгаруулалтын дүнг мэдэгдсэнээс хойш Монгол Улсын Ерөнхий аудиторт гомдол гаргах хугацаа ажлын 3 хоног байх бөгөөд ирүүлсэн гомдлыг ажлын 5 хоногт шийдвэрлэж, хариуг хүргүүлнэ. Гомдол гаргах хугацаа өнгөрсөн эсхүл гомдлыг шийдвэрлэж мэдэгдсэнээс хойш шалгарсан этгээдэд гэрээ байгуулах эрх олгоно.

ТАВ. ШИНЖЭЭЧТЭЙ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

5.1. Төрийн аудитын байгууллага сонгон шалгаруулалтаар "хамгийн сайн" үнэлэгдсэн этгээдэд гэрээ байгуулах тухай мэдэгдэл хүргүүлж шаардлагатай бол хэлэлцээр хийсний үндсэн дээр гэрээ байгуулна. Мэдэгдэл хүлээн авсан этгээд гэрээ байгуулахаас татгалзсан тохиолдолд дараагийн этгээдэд мэдэгдэл хүргүүлж гэрээ байгуулж болно.

5.2. Гэрээг захиалагчийг төлөөлж, Үндэсний аудитын газарт Монгол Улсын Ерөнхий аудитор, эсвэл түүний эрх олгосон албан тушаалтан, аймаг нийслэл дах Төрийн аудитын газарт тэргүүлэх аудитор батална. Шинжээч болон шалгагдагч этгээдийг эрх бүхий этгээд төлөөлж, гэрээг батална.

5.3. Төрийн аудитын байгууллагаас шаардлагатай тохиолдолд аудитын ажлын зорилго, цар хүрээ, хэмжээ нь зохистой, хангалттай хэмжээнд тусгагдсан эсэхийг шалгаж, шинжээчтэй хэлэлцэн тохиролцож, ажлын даалгаварт нэмэлт тодруулга хийж болох бөгөөд энэ журмын 3.3-т заасан нэгжээр хянуулсан байна.

5.4. Төсөвт өртөг нь 100 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил гүйцэтгүүлэх тохиолдолд гүйцэтгэлийн баталгаа шаардах бөгөөд энэ талаар саналын урилгын баримт бичигт тусгасан байна. Гүйцэтгэлийн баталгаа нь гэрээний үнийн дүнгийн 3 хувь байна.

5.5. Шинжээчийн ажлын гүйцэтгэлтэй холбогдох баримт бичиг нь гүйцэтгэлийн баталгааг чөлөөлүүлэх үндэслэл болно.

5.6. Төрийн аудитын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12. 1-д заасан төлөвлөгөөт бус аудит гүйцэтгэхэд шинжээч оролцуулах шаардлага гарсан болон нууцлал зэргээс хамааран энэ журмын 4.1 дэх хэсгийг баримтлахгүйгээр Монгол Улсын Ерөнхий аудитор, эсхүл түүний эрх олгосон албан тушаалтны шийдвэрээр шаардлага хангахуйц этгээдэд санал хүргүүлж, гэрээ байгуулж болно.

5.7. Аудит хийх явцад шинжээчээр нэмэлт ажил гүйцэтгүүлэх шаардлага үүсвэл нэмэлт ажлын өртөг нь анхны гэрээний үнийн 20 хувиас хэтрэхгүй тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулан ажиллуулж болно.

5.8. Шинжээч сонгон шалгаруулалт амжилтгүй болсон тохиолдолд журмын 1.5-д заасан албан тушаалтны шийдвэрээр Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-т заасан мэдээллийн сангаас шаардлага хангасан этгээдтэй гэрээ байгуулж болно.

5.9 Төрийн аудитын байгууллагатай гэрээгээр ажилласан шинжээчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг үндэслэн сонгон шалгаруулалтыг хэрэгжүүлэхгүйгээр дахин гэрээ байгуулан ажиллаж болох бөгөөд шинээр байгуулах гэрээний үнийн дүн нь өмнө байгуулсан гэрээний үнийн дүнгийн 20 хувиас хэтрэхгүй байна.

ЗУРГАА. ШИНЖЭЭЧИЙН ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ЧАНАРЫГ ХЯНАХ

6.1. Шинжээчийн ажлын гүйцэтгэл (явц), тайлан (дүгнэлт) болон ажлын баримтад үе шатны хяналтыг захиалагч нэгж, аудитын багийн албан тушаалтнууд хэрэгжүүлнэ.

6.2. Шинжээч нь гүйцэтгэж буй ажлын явц, эцсийн тайлан, дүгнэлт, ажлын баримтыг аудитын багт цаасан болон цахим хэлбэрээр хүлээлгэн өгч, үе шатны хяналт хийлгэнэ. Шаардлагатай тохиолдолд ажлын гүйцэтгэл, тайлан, дүгнэлтийн талаар дээд шатны албан тушаалтныг оролцуулан танилцуулга, сонсгол зохион байгуулж болно.

6.3. Шинжээч нь аудитын баг болон холбогдох албан тушаалтнаас өгсөн санал, зөвлөмжийг хүлээн авч, тавьсан шаардлагыг хэрэгжүүлэх үүрэг хүлээх бөгөөд хүлээн зөвшөөрөгдсөн ажлын гүйцэтгэлийг захиалагчид гэрээнд заасан хугацаанд баталгаажуулж ирүүлнэ.

6.4. Шинжээч нь аудитын багаас өгсөн санал, зөвлөмжийг тогтоосон хугацаанд хэрэгжүүлээгүй эсхүл шинжээчийн ажлын гүйцэтгэл хангалтгүй, ажлын даалгаварт нийцээгүй болох нь нотлогдсон тохиолдолд аудитын багаас гэрээ цуцлах саналыг холбогдох баримтын хамт Монгол Улсын Ерөнхий аудитор, эсвэл түүний эрх олгосон албан тушаалтанд, аймаг, нийслэл дах Төрийн аудитын газарт Тэргүүлэх аудиторт танилцуулж, шийдвэрлүүлнэ.

6.5. Шинжээч нь гэрээт ажлыг гүйцэтгэхдээ ашиг сонирхлын болон ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд гэрээг цуцална.

6.6. Энэхүү журмын 6.4, 6.5-д заасан нөхцөл үүсэж, гэрээ цуцлагдсан тохиолдолд шинжээч дахин ажиллуулж болох бөгөөд өмнө нь ажилласан шинжээчийг ажиллуулахгүй.

6.7. Шинжээчийн ажлын гүйцэтгэлд хяналт тавих албан тушаалтан нь ажлын гүйцэтгэл хангалттай, шаардлага хангасан тайлан, дүгнэлт, ажлын баримтыг хүлээн авах үүрэгтэй.

6.8. Шаардлагатай тохиолдолд Монгол Улсын Ерөнхий аудитор, эсвэл түүний эрх олгосон албан тушаалтны шийдвэрээр шинжээчийн гүйцэтгэсэн ажилд чанарын хяналт, магадлал хийлгэж болно.

ДОЛОО. ШИНЖЭЭЧТЭЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭГ ҮНЭЛЭХ, ДҮГНЭХ

7.1. Захиалагч нэгж, аудитын баг шинжээчийн ажлын гүйцэтгэлийг энэ журмын дөрөвдүгээр хавсралтын маягт 1-ийн дагуу үнэлгээ өгөх бөгөөд шинжээчид танилцуулж, баримтжуулсан байна.

7.2. Шинжээчийн ажлын гүйцэтгэлийг нийт "100 оноо"-оор үнэлэх бөгөөд онооны үзүүлэлтээс хамаарч, дараах үнэлгээ өгөгдөнө.

6.2.1. 86-100 хүртэл оноо "Хангалттай"

6.2.2. 71-85 хүртэл оноо "Сайжруулах шаардлагатай"

6.2.3. 0-70 хүртэл оноо "Хангалтгүй"

7.3. Захиалагч нэгж шинжээчийн гүйцэтгэлийг үнэлж, гэрээг дүгнэсэн акт үйлдэн, тайлан, дүгнэлтийн хамт Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч, аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын Тэргүүлэх аудиторт тухай бүр хүргүүлж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэлийн үнэлгээнээс хамаарч, ажлын хөлсийг олгоно.

7.4. Шинжээчийн ажлын гүйцэтгэлийг энэ журмын дөрөвдүгээр хавсралтын маягт 2-ын загвараар акт үйлдэн хүлээлцэнэ.

7.5. Талууд гүйцэтгэлийн баталгаажсан актыг үндэслэн журмын дөрөвдүгээр хавсралтын маягт 3-ын загвараар гэрээг дүгнэнэ.

7.6. Шинжээч ажлын гүйцэтгэлийн үнэлгээ болон гэрээ дүгнэх актыг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд Монгол Улсын Ерөнхий аудиторт гомдол гаргах бөгөөд шийдвэрийг эс зөвшөөрвөл холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлүүлнэ.

НАЙМ. БУСАД

8.1 Шинжээчийн гэрээт ажил нь "Хангалтгүй" үнэлэгдсэн, энэ журмын 6.4-д заасны дагуу гэрээ цуцлагдсан тохиолдолд Төрийн аудитын байгууллагаас 3 жилийн хугацаанд хамтран ажиллахгүй.

8.2. Шинжээч нь ёс зүйн зөрчил гаргасан, хараат бус байдлыг хангаж ажиллаагүй төрийн болон албаны, хувь хүн, байгууллагын нууцыг задруулсан нь тогтоогдсон тохиолдолд төрийн аудитын байгууллагаас 5 жилийн хугацаанд хамтран ажиллахгүй бөгөөд тухайн асуудлыг шийдвэрлүүлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүсэлт гаргана.

8.3. Шинжээчийн сонгон шалгаруулалтыг энэ журмын дагуу зохион байгуулаагүй, ажлын гүйцэтгэлийг үндэслэлгүйгээр буруу үнэлсэн болон шинжээчийн шаардлага хангаагүй тайлан, дүгнэлт, баримт хүлээн авсан нь тогтоогдвол холбогдох албан тушаалтанд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

___o0o___